

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тархмал эрчим хүчний дэд бүтэц ХХК-ны 2025 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2026/130/НА-СТА-ОНӨҮГ

| | |
|---------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p> | <p>Дарга, Тэргүүлэх Аудитор: Г.Нандинжаргал Утас: 327734 Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn</p> <p>Санхүү аудитын албаны ахлах менежер: Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: С.Гантөгс Утас: 315558 Цахим хаяг: gantugss@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Б.Цолмон Утас: 325093 Цахим хаяг: tsolmonba@audit.gov.mn</p> <p>Аудитор: М.Өлзийхишиг Утас: 325093 Цахим хаяг: ulziikhisihiqm@audit.gov.mn</p> |
|---------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

| | |
|------------------------------------------------------------------------------|------------------------------|
| 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ | 2 |
| 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН..... | 4 |
| 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА..... | Error! Bookmark not defined. |
| 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа | Error! Bookmark not defined. |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал | Error! Bookmark not defined. |
| 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт | Error! Bookmark not defined. |
| 3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл | Error! Bookmark not defined. |
| 4. АУДИТЫН ТАЙЛАН | Error! Bookmark not defined. |
| 4.1 Ерөнхий зүйл | Error! Bookmark not defined. |
| 4.2 Материаллаг байдал | Error! Bookmark not defined. |
| 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт | Error! Bookmark not defined. |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | Error! Bookmark not defined. |
| 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | Error! Bookmark not defined. |
| 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ | 12 |
| 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ | 14 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|-------------------------------------------------------|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон улсын стандарт |
| НА | Нотлох аудит |
| НТАГ | Нийслэл дэх Төрийн аудитын газар |
| НББОУС | Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт |
| НИТХТ | Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид |
| ОНӨААТҮГ | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| НЗД | Нийслэлийн засаг дарга |
| ТЭЗҮ | Техник эдийн засгийн үзүүлэлт |
| ХАОАТ | Хүн амын орлогын албан татвар |

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026 - 05 - 13 № 913
танай _____ -ны № _____ -т

ТАРХМАЛ ЭРЧИМ ХҮЧНИЙ ДЭД
БҮТЭЦ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Ч.БАТЗОРИГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Тархмал эрчим хүчний дэд бүтэц ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Тархмал эрчим хүчний дэд бүтэц ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 10 дугаар тогтоолоор Тархмал эрчим хүчний дэд бүтэц ХХК-ийн 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд тайлант оны нийт зардлыг 2,720.5 сая төгрөг байхаар баталж, гүйцэтгэлээр 2,544.9 сая төгрөгийн урсгал зардал гаргаж ажилласан байна.

Аудитын гол асуудал

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн №24/13 дугаар тогтоолоор үүсгэн байгуулж дүрмийн санг 3,000.0 сая төгрөгөөр өсгөсөн байна.

Тархмал эрчим хүчний дэд бүтэц ХХК нь Нийслэл Улаанбаатар хотод сайжруулсан шахмал түлш болон түүхий нүүрсний хэрэглээг үе шаттайгаар арилгах, хийн түлш болон бусад тархмал цэвэр эрчим хүчний шинэ эх үүсвэрт шилжүүлэх, энэ чиглэлийн эрх зүйн орчин, стандарт, норм дүрмийг боловсруулж, 2025 оноос нийт 100,0 мянган айл өрхийг хийн түлш болон бусад цэвэр дулааны эрчим

хүчээр хангах дэд бүтцийг барьж байгуулах үндсэн зорилготой хуулийн этгээд байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг Нийслэлийн Засаг даргын 2026 оны А/233 тоот захирамжаар хангалттай гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР




Г.НАНДИНЖАРГАЛ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон
/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---------------|-----------------------------------------------------------------------|------------------------|------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | - | 6,551,289,025.31 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | - | 502,717,908.26 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | - | 502,717,908.26 |
| 3121 | Төгрөг | - | 502,717,908.26 |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | - | 502,717,908.26 |
| 33 | АВЛАГА | - | 3,784,305,925.47 |
| 33401 | Дансны авлага /ТӨҮГ/ | - | 3,783,842,032.95 |
| 33402 | Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/ | - | 463,892.52 |
| 34 | УРЬДЧИЛГАА | - | 2,207,306,441.58 |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | - | 619,508,291.00 |
| 3471 | Урьдчилгаа тооцоо | - | 1,587,798,150.58 |
| 34713 | Цалингийн урьдчилгаа | - | 1,587,798,150.58 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | - | 56,958,750.00 |
| 354 | Хангамжийн материал | - | 56,958,750.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | - | 704,800.00 |
| 35420 | Аж ахуйн материал | - | 49,153,950.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | - | 7,100,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | - | 280,617,633.75 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | - | 280,617,633.75 |
| 392 | Биет хөрөнгө | - | 269,845,566.25 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | - | 228,197,405.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | - | (56,084,127.08) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | - | 85,612,900.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | - | (4,313,945.00) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | - | 17,000,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | - | (566,666.67) |
| 393 | Биет бус хөрөнгө | - | 10,772,067.50 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | - | (7,675,262.50) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | - | 18,447,330.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | - | 6,831,906,659.06 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | - | 3,769,512,530.52 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | - | 3,769,512,530.52 |
| 413 | Өглөг | - | 99,512,530.52 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 270,000.00 |
| 4136 | Бусад өглөг | - | 99,242,530.52 |
| 41363 | Татварын өглөг/ТӨҮГ/ | - | 1,442,530.52 |
| 41366 | Дансны өглөг /ТӨҮГ/ | - | 97,800,000.00 |
| 414 | Урьдчилж орсон орлого | - | 3,670,000,000.00 |
| 41440 | Бусад урьдчилж орсон орлого | - | 3,670,000,000.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | - | 3,062,394,128.54 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | - | 3,062,394,128.54 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | - | 3,065,619,600.00 |
| 51101 | Өмч:- төрийн | - | 3,000,000,000.00 |
| 51106 | Эздийн өмчийн бусад хэсэг | - | 65,619,600.00 |

Тархмал эрчим хүчний дэд бүтэц ХХК-ны 2025 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

| | | | |
|-------|------------------------------------------------|---|------------------|
| 512 | Хуримтлагдсан үр дүн | - | (3,225,471.46) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (3,225,471.46) |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | - | 6,831,906,659.06 |

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон
/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---------------|-------------------------------------------------------------|------------------------|------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | - | 102,455,794.17 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | - | - |
| 110 | Орлогын албан татвар | - | - |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | - | - |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | - | 102,455,794.17 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | - | 102,455,794.17 |
| 120001 | Хувьцааны ногдол ашиг | - | - |
| 120002 | Хүүгийн орлого | - | - |
| 120003 | Торгуулийн орлого | - | - |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | - | 102,455,794.17 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 102,455,794.17 |
| 120011 | Борлуулалтын өртөг /ТӨҮГ/ | - | - |
| 120012 | Эрхийн шимтгэлийн орлого /ТӨҮГ/ | - | - |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | - | 105,681,265.63 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | - | 105,681,265.63 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | - | 105,681,265.63 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | - | - |
| 210101 | Үндсэн цалин | - | - |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | - | 7,245,681.67 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | - | 7,245,681.67 |
| 210302 | Түлш, халаалт | - | - |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | - | 16,645,801.00 |
| 210401 | Бичиг хэрэг | - | 9,390,038.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | - | - |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | - | 5,355,763.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | - | - |
| 210409 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн/ТӨҮГ/ | - | 1,900,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | - | 172,500.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | - | 172,500.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 81,617,282.96 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 12,977,281.71 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | - |

Тархмал эрчим хүчний дэд бүтэц ХХК-ны 2025 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

| | | | |
|--------|------------------------------------------|---|----------------|
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | - | 68,640,001.25 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | - | (3,225,471.46) |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | - | - |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | - | (3,225,471.46) |

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон
/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | Өмч | Халаасны хувьцаа | Нэмж төлөгдсөн капитал | Хөрөнгийн дахин үнэлгээн ий нэмэгдэл | Гадаад валютийн хөрвүүлэлтийн нөөц | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---------------|------------------------------------------------------------------------|----------------|------------------|------------------------|--------------------------------------|------------------------------------|---------------------------|--------------------|------------------|
| 1 | 2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | - | - | - | - | - | - | - | - |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | - | - | - | - | - | - | - | - |
| 3 | Залруулсан үлдэгдэл | - | - | - | - | - | - | - | - |
| 4 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | - | - | - | - | - | - | - | - |
| 5 | Бусад дэлгэрэнгүй орлого | - | - | - | - | - | - | - | - |
| 6 | Өмчид гарсан өөрчлөлт | - | - | - | - | - | - | - | - |
| 7 | Зарласан ногдол ашиг | - | - | - | - | - | - | - | - |
| 8 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | - | - | - | - | - | - | - | - |
| 9 | 2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | - | - | - | - | - | - | - | - |
| 10 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | - | - | - | - | - | - | - | - |
| 11 | Залруулсан үлдэгдэл | - | - | - | - | - | - | - | - |
| 12 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | - | - | - | - | - | - | (3,225,471.46) | (3,225,471.46) |
| 13 | Бусад дэлгэрэнгүй орлого | - | - | - | - | - | - | - | - |
| 14 | Өмчид гарсан өөрчлөлт | 3,000,000,000. | - | - | - | - | 65,619,600.00 | - | 3,065,619,600.00 |
| 15 | Зарласан ногдол ашиг | - | - | - | - | - | - | - | - |

Тархмал эрчим хүчний дэд бүтэц ХХК-ны 2025 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

| | | | | | | | | | |
|----|--------------------------------------------|-----------------------|---|---|---|---|---------------|----------------|-------------------------|
| 16 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | - | - | - | - | - | - | - | - |
| 17 | 2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 3,000,000,000. | - | - | - | - | 65,619,600.00 | (3,225,471.46) | 3,062,394,128.54 |

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон
/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2024 оны 12 дугаар сарын 31 | 2025 оны 12 дугаар сарын 31 |
|---------------|---------------------------------------------------------------------|-----------------------------|-----------------------------|
| | Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 1 | Үйл ажиллагааны мөнгөн орлогын дун (1) | - | 35,000.00 |
| 12 | Татварын бус орлого | - | 35,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | - | 35,000.00 |
| 120009 | Бусад орлого | - | 35,000.00 |
| 2 | Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн (2) | - | 1,914,428,421.93 |
| 21 | Урсгал зардал | - | 1,914,428,421.93 |
| 210 | Бараа, ажил үйлчилгээний зардал | - | 1,914,428,421.93 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | - | 1,139,501,614.81 |
| 210106 | Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/ | - | 1,139,501,614.81 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | - | 330,864,662.40 |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | - | 330,864,662.40 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | - | 85,620,681.67 |
| 210305 | Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ// | - | 85,620,681.67 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | - | 157,387,481.00 |
| 210409 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/ | - | 55,172,730.00 |
| 210410 | Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ// | - | 102,214,751.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | - | 201,053,982.05 |
| 210816 | Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | - | 127,096,243.05 |
| 210818 | Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/ | - | 73,957,739.00 |
| 3 | Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ (3)=(1)-(2) | - | (1,914,393,421.93) |
| | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 4 | Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дун (4) | - | 128,002,287.18 |
| 140003 | Бусдад олгосон зээл болон урьдчилгааны эргэн төлөлт | - | 25,581,493.01 |
| 140007 | Хүлээн авсан хүүний орлого | - | 102,420,794.17 |
| 5 | Хөрөнгө оруулалтын мөнгөн зардлын дун (5) | - | 711,838,035.00 |
| 22 | Хөрөнгийн зардал | - | 711,838,035.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | - | 711,838,035.00 |
| 225101 | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/ | - | 261,940,705.00 |
| 225102 | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/ | - | 18,447,330.00 |
| 225104 | Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/ | - | 300,000,000.00 |
| 225105 | Бусдад олгосон зээл болон урьдчилгаа /ТӨҮГ/ | - | 131,450,000.00 |
| 6 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ (6)=(4)-(5) | - | (583,835,747.82) |

Тархмал эрчим хүчний дэд бүтэц ХХК-ны 2025 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

| | | | |
|--------|--------------------------------------------------------------|----------|-------------------------|
| | Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | - | - |
| 14 | Бусад эх үүсвэр | - | 3,000,000,000.00 |
| 145008 | Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | - | 3,000,000,000.00 |
| 7 | Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ | <u>-</u> | <u>3,000,000,000.00</u> |
| 8 | Нийт цэвэр мөнгөн гүйлгээ (8)=(3)+(6)+(7) | - | 501,770,830.25 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 502,717,908.26 |

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

| ҮЗҮҮЛЭЛТ | 2025 оны батлагдсан төсөв | Гүйцэтгэл | Хэмнэлт | Хувь |
|-----------------------------------------------------|---------------------------|--------------|-------------|--------|
| 2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,720,548.80 | 2,544,882.80 | 175,666.00 | 93.5 |
| 21 УРСГАЛ ЗАРДАЛ | 2,720,548.80 | 2,544,882.80 | 175,666.00 | 93.5 |
| 210 БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,720,548.80 | 2,544,882.80 | 175,666.00 | 93.5 |
| 2101 Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 1,792,300.00 | 1,417,234.10 | 375,065.90 | 79.1 |
| 210101 Үндсэн цалин | 1,779,000.00 | 1,181,184.10 | 597,815.90 | 66.4 |
| 210102 Нэмэгдэл | - | - | 0.00 | - |
| 210103 Унаа хоолны хөнгөлөлт | 13,300.00 | 144,970.00 | -131,670.00 | 1090.0 |
| 210104 Урамшуулал | 91,080.00 | 91,080.00 | 0.00 | 100.0 |
| 2102 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 235,422.50 | 175,633.00 | 59,789.50 | 74.6 |
| 210201 Тэтгэврийн даатгал | 160,087.30 | 114,654.70 | 45,432.60 | 71.6 |
| 210202 Тэтгэмжийн даатгал | 18,833.80 | 13,899.10 | 4,934.70 | 73.8 |
| 210203 ҮОМШ-ний даатгал | 15,067.04 | 16,930.70 | -1,863.66 | 112.4 |
| 210204 Ажилгүйдлийн даатгал | 3,766.76 | 2,421.60 | 1,345.16 | 64.3 |
| 210205 Эрүүл мэндийн даатгал | 37,667.60 | 27,726.90 | 9,940.70 | 73.6 |
| 2103 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 172,425.00 | 172,425.00 | 0.00 | 100.0 |
| 210304 Байрны түрээс | 172,425.00 | 172,425.00 | 0.00 | 100.0 |

Тархмал эрчим хүчний дэд бүтэц ХХК-ны 2025 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

| | | | | | |
|---------------|------------------------------------------------------------------------|------------------|-----------------|---------------|-------------|
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 122,014.90 | 46,120.70 | 75,894.20 | 37.8 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,775.10 | 1,513.20 | 2,261.90 | 40.1 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 102,600.00 | 32,646.80 | 69,953.20 | 31.8 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 6,780.00 | 6,600.00 | 180.00 | 97.3 |
| 210406 | Бага үнэтэй түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8,859.80 | 5,360.70 | 3,499.10 | 60.5 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 257,485.60 | 289,460.20 | -31,974.60 | 112.4 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 195,000.00 | 217,260.20 | -22,260.20 | 111.4 |
| 210602 | Тавилга | 20,000.00 | 19,700.00 | 300.00 | 98.5 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 20,000.00 | 15,800.00 | 4,200.00 | 79.0 |
| 210604 | Урсгал зардал | 22,485.60 | 36,700.00 | -14,214.40 | 163.2 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 39,160.70 | 9,542.00 | 29,618.70 | 24.4 |
| 210701 | Гадаад албан томилолт | 39,160.70 | 9,542.00 | 29,618.70 | 24.4 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 91,601.90 | 424,617.80 | -333,015.90 | 463.5 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 86,651.90 | 420,567.80 | -333,915.90 | 485.4 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,950.00 | 4,050.00 | 900.00 | 81.8 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,138.20 | 9,850.00 | 288.20 | 97.2 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,138.20 | 9,850.00 | 288.20 | 97.2 |

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,795,455.6 мянган төгрөгийн 2 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

- Зөвлөхийн гэрээгээр гүйцэтгэсэн 22,999.8 мянган төгрөгийн ажлын төлбөрийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийн зардлаар бүртгээгүй цалингийн зардлаар бүртгэсэн байна
- НЗДТГ-тай хийсэн 3,772,455.8 мянган төгрөгийн гэрээний орлогыг гэрээг үндэслэн орж ирээгүй орлогыг орлогоор хүлээн зөвшөөрч орлого дүнгийн тайланд тусгасан байна.

Энэ нь НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 “Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх” болон санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 22,486.2 мянган төгрөгийн зөрчил¹ илэрсэнд зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн зөрчил 22,486.2 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт-1: Төсвийг үрэлгэн зарцуулж хангамжийн материалд 3,236,225.00 (Гурван сая хоёр зуун гучин зургаан мянга хоёр зуун хорин таван төгрөг 00 мөнгө) төгрөгийн цай, цэвэр ус гэх мэт хэрэглээний зүйлс худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д “*үр ашигтай байх*”, 4.1.6-д “*сахилга баттай байх*”, 12 дугаар зүйлийн 12.1.4-д “*хуулиар зөвшөөрөөгүй бусад*” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Кофе, цай, нэрийн хуудасны төлбөрт төлсөн 3,236.2 мянган төгрөгийг төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг харуулав. Үүнд:

1. Худалдан авалттай холбоотой асуудал:

Илрүүлэлт-1: Худалдан авалтын төлөвлөгөөг бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцлаагүй, захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж 19,250.0 мянган төгрөгийн худалдан авах ажиллагаа зохион байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 “Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хууль журмыг мөрдөж, ижил төсөөтэй бараа, ажил үйлчилгээг багцалж худалдан авах ажиллагааг зохион байгуулах зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 30 ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------|--------------------|-----------------------------------|-----|--------------------------|--------------------|------------|--------------------|--------------|-----|---------|-----|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Залруулсан | | Залруулаагүй | | Тоо | Дүн |
| | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | | |
| Зөвлөхийн гэрээгээр гүйцэтгэсэн ажлын төлбөрийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийн зардлаар бүртгээгүй цалингийн зардлаар бүртгэсэн байна | 1 | 22,999.8 | | | 1 | 22,999.8 | 1 | 22,999.8 | | | | |
| НЗДТГ-тай хийсэн гэрээний орлогыг гэрээг үндэслэн орж ирээгүй орлогыг орлогоор хүлээн зөвшөөрч орлого дүнгийн тайланд тусгасан байна. | 1 | 3,772,455.8 | | | 1 | 3,772,455.8 | 1 | 3,772,455.8 | | | | |
| Дүн | 2 | 3,795,455.6 | | | 2 | 3,795,455.6 | 2 | 3,795,455.6 | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------|-----------------|---------------|----------------|-----------------|-----|----------|-----------------|--------------------------------------|-----|-----|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Төсвийг үрэлгэн зарцуулж хангамжид материалд кофе, нэрийн хуудас хэвлүүлсэн байна | 1 | 3,236.2 | 1 | 3,236.2 | | | | | | | | |
| Худалдан авалтын төлөвлөгөөгөө бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцлаагүй Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулсан байна. | 1 | 19,250.0 | | | | | 1 | 19,250.0 | | | | |
| Дүн | 2 | 22,486.2 | 1 | 3,236.2 | | | 1 | 19,250.0 | | | | |



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 07 сарын 13 өдөр

Дугаар 250/А0021554

Улаанбаатар хот

НТНТ-2026/130/НА-СТН-ОНӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Тархмал эрчим хүчний дэд бүтэц ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийг үрэлгэн зарцуулж хангамжийн материалд 3,236,225.00 (Гурван сая хоёр зуун гучин зургаан мянга хоёр зуун хорин таван төгрөг 00 мөнгө) төгрөгийн цай, цэвэр ус гэх мэт хэрэглээний зүйлс худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "үр ашигтай байх", 4.1.6-д "сахилга баттай байх", 12 дугаар зүйлийн 12.1.4-д "хуулиар зөвшөөрөөгүй бусад" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, даатан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" заалтад заасныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Байгууллагын зардлаар цай, кофе, цэвэр ус гэх мэт хэрэглээний зүйлс худалдан авсан 3,236,225.00 (Гурван сая хоёр зуун гучин зургаан мянга хоёр зуун хорин таван төгрөг 00 мөнгө) төгрөгийг Тархмал эрчим хүчний дэд бүтэц ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Батзориг, нягтлан бодогч С.Хажидсүрэн нараар нөхөн төлүүлж, Нийслэл дэх Төрийн аудитын газрын төрийн сан дахь НТАГ-ын хүү торгуулийн өрлогын MN440090100200000908 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Тархмал эрчим хүчний дэд бүтэц ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Батзориг, нягтлан бодогч С.Хажидсүрэн нар хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

С.НАНДИНЖАРГАЛ
С.ГАНТӨГС
М.ӨЛЗИЙХИШИГ

¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г хөрпус, 5 давхар

1426110095